



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№189 /399/

2022.10.21

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 150 ДУГААР АНГИЙН 50 ЖИЛ, МОТОБУУДЛАГЫН МЭРГЭЖЛИЙН ТУСГАЙ БАТАЛЬОН БАЙГУУЛАГДСАНЫ 25 ЖИЛИЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ!

МЭНДЧИЛГЭЭ



Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 150 дугаар анги үүсэн байгуулагдсаны 50 жил, "ЭЛИТ"-ийн батальон хэмээн алдаршсан Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальон"-ы 25 жилийн ойн баярын мэндийг ангийнхаа баялаг түүхийг бүтээхэд бие сэтгэл, мэдлэг боловсрол, хөдөлмөр зүтгэлээ дайчлан үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн удирдлага, хамт олон, тэднийхээ залгамж болж үйл хэргийг түүчээлэн өндөрт өргөн яваа эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, ажилтан албан хаагчид, мөн даян Дэлхийн энхийн төлөө үүргээ нэртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагч Та бүхэндээ ТХЦК-ийн нэрийн өмнөөс түүхт ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж!

Тэртээх 1972 онд Батлан хамгаалахын сайдын тушаалаар Ардын Армийн 150 дугаар анги буюу "Ардын Армийн Сургуулийн тусгай батальон"-ыг байгуулж, энэ цагаасаа эхлэн бага дарга, бага мэргэжилтнүүдийг 25 төрлийн мэргэжлээр 13800 гаруй цэргийн бага дарга, бага мэргэжилтэн бэлтгэн сургаж, ардын армийн анги, салбаруудад хуваарилсан нь цэргийн сургалт бэлтгэл, бэлэн байдалд үнэтэй хувь нэмэр оруулсан түүхэн гавьяатай юм.

Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн хүмүүнлэг ардчилсан нийгэм рүү тайван замаар шилжсэн 1990 оны эхэн үед улс орны нийгэм эдийн засаг өөрчлөгдөж, шинэ Үндсэн хуульд Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байна

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ
БРИГАДЫН ГЕНЕРАЛ
Б.БААТАР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн 50 жил, Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальон байгуулагдсаны 25 жилийн ойд зориулсан "Зэвсэгт хүчний хагас зууны хөгжил-150 дугаар анги" сэдэвт эрдэм шинжилгээний онол, практикийн бага хурлыг ҮБХИС-ийн Сүбээдэй танхимд амжилттай зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний хуралд Батлан хамгаалах яам, ЗХЖШ, Зэвсэгт хүчний тусгай хүчний цэргийн командлал, Хуурай замын цэргийн командлал, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, Батлан хамгаалах удирдлагын академийн хүндэт

доктор, профессор, эрдэмтэн судлаачид, Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн үе үеийн захирагч, удирдлага бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцов.

Хурлыг нээж Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн захирагч хурандаа Б.Олзбаяр урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн эрхэм генерал, офицер, ахлагч, доктор, профессор, эрдэмтэн, судлаачид, эх орноо батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр, бүтээл залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчдынхаа амрыг эрэн мэндчилээд эл ангийн түүхэн хугацааны ололт амжилт, туршлага, сургамжуудыг хэлэлцэж

ирээдүйн чиг хандлагыг зөв зүйтэй тодорхойлоход хамтран ажиллана гэж найдаж байгаагаа илэрхийлсэн юм.

Хурлаар "Зэвсэгт хүчний хагас зууны хөгжил-150 дугаар анги", "Ардын арми 150 дугаар анги, "Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальон", "Зэвсэгт хүчний хөгжилд Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальоны оролцоо", "Тусгай хүчний цэрэг" зэрэг ерөнхий сэдвүүдийн хүрээнд эрдэмтэн, судлаачид, алба хаагчид санал хүсэлтээ солилцож цаашдын эл ангийн хөгжлийн чиг хандлагад оруулах өөрчлөлт, шинэчлэлт, анхаарах шаардлагатай чухал асуудлуудыг хэлэлцлээ.

ХЭЭР ХЭВТЭХ ЯС НЭГ, ХЭВЛИЙД УРСАХ ЦУС НЭГ ТЭД БОЛ ЭЛИТИЙН БАТАЛЬОН



Ард олондоо Элитийн батальон хэмээн алдаршсан Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн 50 жил, Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальон байгуулагдсаны 25 жилийн ойн баярын хурал ёслол төгөлдөр болж байна.

Эл баярын хуралд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ТХЦК-ийн командлагч бригадын генерал Б.Баатар, Бэлтгэл хошууч генерал Б.Баярмагнай нарын тэргүүтэй БХЯ, ЗХЖШ төлөөлөл, Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн үе үеийн захирагч, удирдлага, хамт олон, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчдын төлөөлөл хүрэлцэн иржээ.

Зэвсэгт хүчний 150 дугаар анги нь 1972 оноос Ардын армийн ноён нуруу болсон офицеруудын шадар туслагч бага дарга, бага мэргэжилтнийг бэлтгэх эрхэм үйлсийг түүчээлж, улмаар 1997 онд Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Цэргийн шинэчлэлийн бодлогын хүрээнд Батлан хамгаалахын сайдын 1997 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн тушаалаар тайван цагийн бүтэц, орон тоонд шилжиж, зохион

сэтгэлээр зүтгэсэн ахмад дайчид, алба хаагчид, үе үеийн захирагч нар босож Цэргийн гавьяаны улаан тугийн одонт эл ангийнхаа байлдааны тугийг хүндэтгэлийн байранд ёслол төгөлдөр залснаар баярын хурлын үйл ажиллагаа эхэлж байна.

Ангийн захирагч хурандаа Б.Олзбаяр түүхт ойн баярт хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн зэрэгцээ элитийн батальоны түүхэн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлсэн юм.

Үргэлжлүүлэн ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Тусгай хүчний цэргийн командлагч Б.Баатар, ангийн ахмад дайчдын төлөөлөл бие бүрэлдэхүүнд баяр хүргэж үг хэллээ.



байгуулалтаараа байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх, Энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадвар бүхий Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальон болон шинэчлэн байгуулагдсан түүхтэй.

Тус анги нь үүсгэн байгуулагдсан цагаасаа шинэ цагийн Зэвсэгт хүчний мэргэжлийн цэргийн суурийг тавьж Энхийг дэмжих болон Олон Улсын цэргийн ажиллагаануудад анхдагч нь байж, ангийнхаа Байлдааны туганд алдар гавьяа, амжилт бүтээлийн баталгаа болсон Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоо хүндэтгэлтэйгээр залжээ. Тухайлбал эл анги нь "Зэвсэгт хүчний тэргүүний анги" болзлыг хоёр удаа, Биенийн тамир, спортын уралдаан тэмцээнээр хошуучлагч ангийн болзлыг 16 дахь удаагаа хангаж алдар хүндээ бататгасаар ирсэн дайчин уламжлал нь өнөөгийн Тусгай хүчний цэргийн суурь хэрхэн тавигдаж ирснийг гэрчилж буй юм.

Офицеруудын ордны их танхимыг дүүргэн чуулсан, эх орноо батлан хамгаалах үйлс, тус ангид хөргүй




Ахмадууд ярьж байна

ЭЛИТИЙН БАТАЛЬОНД ХҮЧИН ЗҮТГЭЖ ЯВСНААРАА БАХАРХДАГ

Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн захирагчийн сургалт, хүмүүжил эрхэлсэн орлогч асан бэлтгэл дэд хурандаа А.ЛҮНДЭВДЭЛЭГ:

-Би хуучнаар ЗХУ-ын Одесс хотын Цэргийн нэгдсэн сургуулийг төгссөн. Монголын Улсын Зэвсэгт хүчинд 25 жил ажиллахдаа хамгийн их бахархаж, түүх дурсамж бүтээж, омогшин дурсах дурсамжтай үлдсэн анги бол ард олондоо Элитийн батальон, Бага дарга нарын сургууль гэж алдаршсан 150 дугаар ангид захирагчийн орлогчоор ажиллаж байх үе гэж боддог. Эл анги нь Монгол Улсын Зэвсэгт хүчний гол ноён нуруу, тулах цэг гэж хэлж болохуйц шилдэг бага дарга нарыг бэлтгэдгээрээ онцлог. 150 дугаар ангиас бэлтгэгдэн гарсан бага дарга нар нь цэргийн ерөнхий мэдлэг, ур чадвар, бие бялдрын хувьд бусдаас хол тасархай байдаг нь илт ажиглагддаг. Түүнчлэн эл анги энхийг дэмжих ажиллагаанд анхлан үүрэг гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэж, дотоодын болоод гадаадын армийн тэмцээнд амжилттай оролцож, улс эх орныхоо нэрийг өндөрт өргөж явдгаар нь цэргийн хүмүүс бид үргэлж бахархаж учиртай. Цэргийн хүн гэдэг улс орны бүрэн



бүтэн байдал, ард иргэдийн энх тунх амьдралын төлөө өөрийгөө зориулдаг, дайн байлдааны болоод энх цагийн бүтээн байгуулалтын гээд ямар ч хүнд хэцүү цагийн байдалд өргөсөн тангарагтаа үнэнчээр зогсдог, эрэлхэг баатрууд юм. Ингээд Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн эрхэм ахмад дайчид, үе үеийн захирагч, алба хаагчид та бүхэнд эл анги байгуулагдсаны 50, Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальон байгуулагдсаны 25 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Та бүгдийн цаашдын ажил, амьдрал үргэлж өлзийтэй байх болтугай.

1981 ОНЫ УЛСЫН БАЯР НААДМЫН ТЕХНИКИЙН ПАРАДАД АНГИА ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОЖ БАЙЛАА

Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн зэвсэглэл техник эрхэлсэн орлогч асан бэлтгэл дэд хурандаа Б.ПҮРЭВ:

-Миний бие эл алдар түүхт 150 дугаар ангид 1973-1994 оныг хүртэлх хугацаанд ажилласан. Анх тус ангидаа хугацаат цэргийн албанд татагдан очоод цэргийн амьдралын сайн сайхан, хатуу хөтүүг туулах үедээ байлдагчаас бага дарга болж дэвшсэн нь маш их урам зориг итгэлийг төрүүлсэн. Улмаар эл ангидаа улиран цэргийн хүн болох сонголтыг хийж ахлагч болсны дараагаар цэргийн их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлж офицеруудын эгнээнд шилжин шижигнэсэн сайхан залуучуудтай мөр зэрэгцэн тус албандаа зүтгэж явлаа. Энэ ангид ажиллах хугацаандаа жолоо буудлагын зааварлагч багш, явган цэргийн байлдааны машины ротын техникийн орлогч, сургалт эрхэлсэн орлогч, ротын захирагч гэсэн албан тушаалыг шат дараалан хашиж цэрэг дайчдын сургалт, хүмүүжил болоод анги байгууллагын зорилго зорилтыг цаг хугацаанд нь биелүүлэхэд хүчин зүтгэж байв.



Миний бие 1981, 1986 оны Улсын баяр наадмын техникийн парадад ангиа төлөөлөн оролцож байснаараа бахархаж, омогшиж явдаг даа. Өнөөдөр хуучин цагт хамтран зүтгэж явсан журмын нөхөд, дарга нар маань хуран чуулсан, дурсамж дурдатгалаа хуваалцсан сайхан өдөр болж байна. Тэднийгээ харсан чинь эргээд цэл залуу насандаа очсон мэт санагдлаа. Энэ сайхан өдөр ангийнхаа түүхт ойг хамтдаа тэмдэглэж буй журмын нөхөд, ахмад дайчид, алба хаагчид, үе үеийн ангийн захирагч нартаа баярын мэнд хүргэе. Та бүхэн сайхан баярлаарай.

ЭСА-НЫ ЖИМИЙГ АНХЛАН ТАТАЖ, МОНГОЛ ЦЭРГИЙГ ДЭЛХИЙД ТАНИУЛСАН ХАМТ ОЛОН



Захирагчийн орлогч, Ар талын дарга асан бэлтгэл дэд хурандаа Ж.ЦЭН-ОЙДОВ:

-Миний ажил, амьдралын 30 жилийн хугацаа Зэвсэгт хүчин хэмээх өнөр айлтай салшгүй холбоотой. Тодруулбал, би 1989-2019 онд Зэвсэгт хүчинд алба хаасан бөгөөд энэ хугацаанд зэвсгийн нярав, зэвсгийн албаны дарга, хангалтын офицер, ар талын даргын албан тушаалыг шат дараалан хашсан. Ардын Армийн 150 дугаар анги буюу ард олондоо Элитийн батальон нэрээрээ алдаршсан

тус ангид 2014 онд ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдож, 2019 оныг хүртэл Захирагчийн орлогч, Ар талын даргын албан тушаалыг хашаад гавьяаныхаа амралтад гарсан.

Манай ангийн бие бүрэлдэхүүн бол мотоуудлагын мэргэжлийн тусгай батальонд алба хаадаг гэдэг утгаараа урлаг, спорт, мэргэжлийн ур чадвар гээд ер нь бүхий л талаар бусдаас илт ялгарч, давуу байж чаддаг нь бидний төдийгүй Зэвсэгт хүчний бахархал юм. Тэр тусмаа дэлхий дахинд энх тайвныг тогтоох эрхэм бөгөөд хариуцлагатай албаны жимийг анхлан татаж, энэхүү үүргээ нэр төртэй биелүүлэн, монгол цэргийн нэр хүндийг дэлхийд таниулсан анхдагчид эл ангиар овоглогддог нь бас нэгэн бахархал юм шүү дээ. Миний хувьд энэхүү ангид алба хаах хугацаандаа хамт олныхоо сурч боловсрох, хөгжиж дэвших, ажиллаж, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэхэд нэлээд анхааран ажилладаг байлаа. Ингээд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн 50, Мотоуудлагын мэргэжлийн тусгай батальоны 25 жилийн ойн баярын мэндийг эл ангиар овоглогдсон хэн бүхэнд уламжилж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсье. Түүнчлэн өдгөөгийн нийт бие бүрэлдэхүүнд ажлын өндөр амжилтыг хүсье.

ӨДИЙ ЗЭРЭГТЭЭ ЯВАА МИНЬ ЭНЭ АНГИЙН АЧ, ТУС



Бэлтгэл ахлах ахлагч Б.УРАНЧИМЭГ:

-1998 онд Мотоуудлагын тусгай батальон байгуулагдаад хамгийн анхны

боловсон хүчнийг бэлтгэж эхлэхэд түүний нэг нь болж эл ангиас ажил, амьдралын анхны гараагаа эхлүүлснээс хойш тасралтгүй 24 жил тус албандаа зүтгэжээ. Буудагч, тасгийн захирагч, нууцын хэрэг хөтөлгөч, нууцын дарга, архивын эрхлэгчээр ажиллаж байгаад энэ онд тэтгэвэртээ гарсан. Миний амьдралын бүхий л сайхан дурсамж энэ ангитай салшгүй холбоотой. Тухайлбал ханьтайгаа энэ ангид анх танилцаж, гэр бүл зохион 3 сайхан хүүхдийн аав, ээж болоод өнөр өтгөн, аз жаргалтай амьдарч байна. Миний хань ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Н.Баасан гэж хүн бий.

Миний хувьд Элитийн батальоноороо үргэлж бахархаж, бусдад сурталчилж явах болно. Миний өдий зэрэгтээ яваа минь энэ ангийн хайр, хишгийн ач тус гэж боддог. Өнөөдөр надад зааж сургаж явсан үе үеийн захирагч, дарга, хамтран ажиллаж байсан алба хаагчид хүрэлцэн ирсэн байна. Хэдий тэтгэвэртээ гараад удаагүй байгаа ч тэднийгээ маш их санажээ. Сайхан байна, баяр бахдал дүүрэн байна. Та бүгд сайхан баярлаарай.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БРЭНД БОЛСОН АНГИ

Бэлтгэл сургагч ахлагч О.ААБАЯР:

-Анх дунд сургуулиа дөнгөж төгсөөд байхдаа Элитийн батальон гэж дандаа шилдэг хүмүүсийг авдаг газар байгуулагджээ гэдгийг сонссон юм. Тэгээд л 1998 онд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн Ахлагч бэлтгэх төвд суралцаж, 1999 онд төгсөөд тус ангитайгаа 25 жил амьдралынхаа заяаг холбоод өнгөрсөн 7 дугаар сард цэргийн тэтгэвэрт гарсан. Тухайн үед намайг шинэхэн ахлагч байхад манай ангийн захирагч хурандаа Б.Цэрэнчимэд байлаа. Химийн багшаар одоогийн ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ротын даргаар одоогийн Тусгай хүчний командлагч бригадын генерал Б.Баатар гээд л эдүгээ Зэвсэгт хүчнийг толгойлон авч явж байгаа шилдэг боловсон хүчнүүд манай ангиас төрөн гарчээ. 1999 онд төгссөн манай ангийн ахлагч нар ч бас шилдэг залуус байсан юм. Тухайлбал, тэргүүн ахлагч Н.Баасан, Н.Бат-Эрдэнэ, Г.Наранпүрэв, Д.Энхбаяр гээд л хөвөрч өгнө. Эдгээр он жилүүдэд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийнхаа шилдэг залуустай мөр зэрэгцэн алба хааж явсан минь надад нэр төрийн хэрэг юм. Ингээд та бүхэндээ Зэвсэг хүчиндээ өөрсдийн амжилт, бүтээлээрээ нэгэнт брэнд болсон 150 дугаар ангийнхаа түүхт ойн мэндийг



өргөн дөвшүүлэхийн ялдамд Элитийн батальоноор овоглосон үе үеийн офицер, ахлагч, ажилтан алба хаагчдаа эрүүл энх, энэ хорвоогийн хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

САЙХАН ХАМТ ОЛОНТОЙ БАЙНА ГЭДЭГ ХАМГААС ЧУХАЛ

Засварын тасгийн дарга бэлтгэл ахлах ахлагч Д.ДЭМБЭРЭЛ:

-1997 онд Элитийн батальон байгуулагдахад н.Цэрэнчимэд хурандаагийн жолоочоор ажиллаж, анги эмхэтгэн байгуулах ажилд оролцож эл ангитай холбогдсон түүхтэй. Засварын тасгийн даргаар 13 жил ажиллаад 2008 онд тэтгэвэртээ гарсан. Миний хувьд энэ ангийн ар тал, техникийг бүрэн хариуцдаг байлаа. Хүн ажил дээрээ амьдралынхаа маш олон цагийг өнгөрүүлдэг шүү дээ. Тиймээс сайхан хамт олонтой байна гэдэг хамгаас чухал гэдэг юм билээ. Миний хувьд амьдралын түшиг тулгуур болсон олон сайхан найз нөхдийг эл ангиасаа олж авсан. Бахархаж явдаг зүйл гэвэл Иракийн Эрх чөлөө ажиллагааны II, Сьерра-Льон Улсад явагдсан энхийг сахиулах ажиллагааны I ээлжид эх орноо төлөөлөн явсан



андагчдын нэг болж үүрэг гүйцэтгэсэн явдал юм. Энэ мэт яривал ном, сударт ч дэлгэж багтаахад бэрх их зүйл бий учир энэ хүрээд өндөрлөө. Ангийнхаа түүхт ойг тэмдэглэж буй хамт олондоо халуун баярыг хүргэхийн сацуу эрүүл энх явахыг хүсье.